# “БиДиСЕК ҮЦК” ХК

Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Залуучуудын өргөн чөлөө-27/1
Утас: 11-313108, Факс: 11-323411
www.bdsec.mn


Огноо 2018.06.05 Дугаар 18/239

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-д

Анхдагч зах зээлийн арилжааны тухай

Андеррайтер нь Үнэт цаас гаргагч Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн-н хувьцааг анхдагч зах зээлд Санхүүгийг зохицуулах хорооны 2018 оны 05 сарын 23-ны өдрийн 187 тоот тогтоолд заасны дагуу нийт 101,100 ширхэг хувьцааг нэр бүхий иргэдэд нэр заан эзэмшүүлэн, үлдэх 3,898,900 ширхэг хувьцааг МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын гуравдугаар зүйлд заасны дагуу тогтоосон үнийн аргаар санал болгох ба эрэлт давсан нөхцөлд Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн-ийн үнэт цаасны танилцуулгын 2.4.4-д тусгасны дагуу захиалга бүрийн 2,500,000 хүртэлх төгрөгийн худалдан авах захиалгыг бүрэн биелүүлэн үлдэх хувьцааг 2,500,000 төгрөгөөс илүү гарсан захиалгын дүнтэй харьцуулан хувь тэнцүүлэн арилжих зарчмыг баримтлана.

Хувьцааны захиалгын тоо хэтэрснээс үүдэн тогтоосон босго дүнгээр захиалгыг биелүүлэх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдол бүрд босго үнийн дүнг 50 хүртэлх хувиар бууруулан шинэчлэн тогтооно. Ингэхдээ үнэт цаас гаргагч болон андеррайтер нь МХБ-тэй зөвшилцөнө.

Иймд дээр дурдсан нөхцлийн дагуу анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулж өгнө үү.

ХҮНДЭТГЭСЭН,

Б.ЛХАГВАДОРЖ
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ